



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 0/223

Улаанбаатар хот

“Барилга байгууламж данснаас хасах тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 29/32 дугаар тогтоол, Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2020 оны 16 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол шуудан” ХК-ийн 20 дугаар салбарын түрээсээр эзэмшиж буй Сүхбаатар 7 дугаар хороо, 11 дүгээр хорооллын 5а байрны 02 тоотын 59,2 мкв талбайтай 48 585 319 /дөчин найман сая таван зуун наян таван мянга гурван зуун арван ес/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий байрыг Иргэний хуулийн 105 дугаар зүйлийн дагуу тэргүүн ээлжинд санал болгон хувьчилсан тул данс бүртгэлээс хасахыг Ерөнхий нягтлан бодогч Н.Уранчимэгт зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд холбогдох өөрчлөлт хийхийг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга А.Мөнгөнд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115070000547